



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/87

Хархорин сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын 2024 оны А/59 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны 2024 оны 07 дугаар зөвлөмжийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих "Хархорин сумын 4, 5, 6, 7, 8 дугаар багт малын тэжээлийн ургамал тариалах үр нийлүүлэх" тендерийг 59,807,500 (тавин есөн сая найман зуун долоон мянга таван зуу) төгрөгөөр "Бат ундарга ХЭТ" ХХК-иар нийлүүлүүлсүгэй.

2. Гэрээ байгуулж, гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг нягтлан бодогч (О.Гангаацэрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн (С.Мөнхсоёл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Г.ОДГЭРЭЛ



401100173